

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Зуух №5 их засвар Багц-1 халах гадаргуу, шугам хоолойн их засвар хийж гүйцэтгэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2021-АУ/03**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Зуух №5-н Халах гадаргуу, шугам хоолойн их засвар Багц-1** хийж гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 100.000 /зуун мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2019, 2020он тус бүрээр/
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. /2019, 2020он/
4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2019, 2020 он/
5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагатай /80кгх/см²-аас дээш даралттай зуухны угсралт/

Тендерийн хамт Төсөвт өртгийн үнийн дүнгийн 2%-тай тэнцүү дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр дуустал

Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,
“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 30 тоот өрөө Худалдан авах
ажиллагааны хэлтэс Утас: 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309, 7000-1357**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


ТӨМӨРХУЯГ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА,  В.ЛХАГВАДОРЖ